



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/252
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Улсын ерөнхий прокурорын Тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын ерөнхий прокурорын Тамгын газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын ерөнхий прокурорын Тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгөт өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хууль, УСНББӨУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргэнлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга, тэргүүлэх
аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740
chantsaldulamp@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5. Материаллаг байдал.....	5
6. Дотоод хяналт.....	5
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	6
8. Шилэн дансны мэдээлэл.....	6
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	7
10. Гол, онцлог гүйлгээний талаар.....	7
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	8
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	12
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	12
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	12
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
17. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	13

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд УЕП-ын Тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд САГ/2017/364/13-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

УЕП-ын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

УЕП-ын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Нэгтгэсэн тайлангийн аудитын алба /НТАА/-ны аудитор П.Чанцалдулам хэрэгжүүлэв.

УЕП-ын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 9-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд УЕП-ын Тамгын газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн

сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ын 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ажиллаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Ерөнхий прокурорын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болно.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг баталгаатай хангах явдлыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэвшүүлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, прокурорын ёс зүйг чандлан сахиж, мэргэжлийн өндөр ур чадвар, хууль дээдлэх зарчимд түшиглэсэн хууль сахиулах шударга тогтолцоог бий болгох явдал нь Прокурорын байгууллагын эн тэргүүний зорилт юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна” мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу УЕП-ын Тамгын газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг УЕП-ын Тамгын газрын дарга үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайн байгууллагын 2016 оны төсвийн санхүүжилтийг Сангийн яамны Төрийн сангаас олгосон байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиудыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар УЕП-ын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 15 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

Тайлант онд кассанд цайны газрын түрээсийн орлого 8.3 сая, сургалтын танхимын түрээсийн орлого 2.7 сая, туслах үйл ажиллагаа буюу малын орлого 1.2 сая, нярав Ц.Батболдоос 0.6 сая, нийт 12.8 сая төгрөгийн орлогыг бэлнээр цуглуулан бүртгэж, нийт 8.7 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох” 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна” гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

Мөн тайлант онд Улсын ерөнхий прокурорын 2016 оны Б/371, А/52, А/36 дугаар тушаалуудаар УЕП-ын Тамгын газарт нийт 1,060.2 сая төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгэж, нийт 61.7 сая төгрөгийн хөрөнгийг харьяа прокурорын байгууллагуудад балансаас балансад шилжүүлсэн байна.

УЕП-ын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

УЕП-ын Тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тооцоолох компаний "Acolous" програмыг ашиглан санхүүгийн тайланг боловсруулан гаргасан байна.

Тав. Материаллаг байдлыг тодорхойлох:

Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвөөс санхүүждэг, 100 хувь төрийн өмчит байгууллага тул материаллаг байдлын суурийг тооцоходоо төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар тооцоход 53.8 сая төгрөг байна.

Зургаа. Дотоод хяналтын талаар

Улсын ерөнхий прокурорын 2015 оны А/22 дугаар тушаалаар тус байгууллагын бүтэц, орон тоог баталж, Дотоод аюулгүй байдлын хэлтсийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, УЕП-ын туслах, хэлтсийн дарга-1, хяналтын прокурор-4 дотоод аудитор-1 гэсэн орон тоотойгоор ажил үүргээ гүйцэтгэж иржээ.

Дотоод аюулгүй байдлын хэлтэс нь улирал бүр ажлын төлөвлөгөө гарган батлуулж ажилладаг бөгөөд дотоод аудитор нь харьяа прокурорын байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөн, бэлэн мөнгөний зарлагын гүйлгээнд хяналт тавьж, ажлаа Улсын ерөнхий прокурор болон түүний дэргэдэх зөвлөлийн хуралд тайлагнадаг байна.

УЕП-ын Тамгын газрын даргын 2016 оны А/15 дугаар тушаалаар "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг шинэчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, гадаад шилжилт хөдөлгөөн, хөрөнгө актлаж устгах, худалдан борлуулах, үнэлгээ тогтоох, хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэж шийдвэр, дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг байна.

Дотоод аюулгүй байдлын хэлтсээс Тамгын газрын 2016 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд аудит хийсэн боловч дотоод аудитор ажлаасаа чөлөөлөгдөж, тухайн орон тоон дээр өнөөг хүртэл ажилтан томилогдоогүйгээс тайлант онд дотоод аудитын тайлан, зөвлөмж өгөөгүй байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад мөнгөн хөрөнгөтэй холбоотой дотоод хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн

хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

УЕП-ын Тамгын газар нь 2016 онд нийт 2,912.7 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй, гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал төсвийн санхүүжилтэд 2,912.7 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 12.0 сая төгрөгийн орлого хүлээн авч, гүйцэтгэлээр 2,914.1 сая төгрөг зарцуулснаас 37,343.54 төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, хөрөнгө оруулалтын зардалд 6.5 сая төгрөгийг зарцуулж, 4.1 сая төгрөгийн кассын үлдэгдэлтэй гарсан байна.

Төсөвт зардлын санхүүжилт болон төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг сар тутам гаргаж төсвийн ерөнхий менежер /ТГД/-т танилцуулж, зардлын хэтрэлт, хэмнэлтэд анхаарал хандуулан ажилласнаар батлагдсан төсөвт багтаан зарцуулалт гаргажээ.

Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

- Улсын ерөнхий прокурорын сайтад шилэн данс, ил тод байдал гэсэн хуудас байгаа боловч ил тод байдлын хуудасруу ороход мэдээлэл гарч ирэхгүй байна.
- УЕП-ын Тамгын газрын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн хэмнэлт, хэтрэлтийн тайлбар, 5 сая төгрөгөөс дээших 15 ажил гүйлгээний нийт 2,235.8 сая төгрөгийн орлого, 40 ажил гүйлгээний 1,183.1 сая төгрөгийн зарлагын баримт материал зэрэг мэдээллийг байршуулжээ.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 16 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Завсрын аудитаар УЕП-ын Тамгын газрын 3 дугаар улирлын санхүүгийн тайлан болон холбогдох ажил гүйлгээнд аудит хийж, уг аудитаар илрүүлсэн асуудалд тухайлсан аудитын зөвлөмж өгөөгүй бөгөөд жилийн эцсийн аудитын дүгнэлтэд хамруулахаар тохирсон болно.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаар

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц

хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, бараа материал, үндсэн хөрөнгө, төсөвт зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

- Бараа материалын дансанд тайлант хугацаанд хамгийн өндөр худалдан авалт хийгдсэн данс нь бичиг хэргийн материал 28.8 сая, аж ахуйн материал 33.9 сая, сэлбэг хэрэгсэл 27.0 сая, шатах тослох материал 69.4 сая төгрөг байна. Сэжуд авто ХХК-иас нийт 13.6 сая төгрөгийн сэлбэг авснаас 10.8 сая төгрөг автомашины дугуй байна. Мөн Магнай трейд ХХК-иас нийт 61.7 сая төгрөгийн шатахууны худалдан авалтыг хийсэн байна.
- Бараа үйлчилгээ худалдан бэлтгэхтэй холбоотой ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад тайлант хугацаанд худалдан бэлтгэх ажил, үйлчилгээг олон нийтэд нээлттэй зарлаж, үнийн саналын судалгаа авалгүйгээр дараах байгууллагуудаас худалдан авалт хийжээ.

(сая.төг)

№	Харилцагч байгууллага	Бараа, үйлчилгээ	2015 оны гүйцэтгэл	2016 оны 12 сар	
				төсөв	Гүйцэтгэл
1	Магнай трейд ХХК	шатахуун	47.4	52.1	61.7
2	Жем нет ХХК	Интернетийн төлбөр	33.2	31.7	31.7
3	Тэнгэр даатгал ХХК	Даатгалын үйлчилгээ	29.6	39.1	31.2
4	Саммит компьютер ХХК	Вирусын програмын төлбөр	11.7		12.4
5	Таван богд менежмент ХХК	Бичгийн цаас	2.7	12.2	4.9

Завсрын аудитаар ТБОНӨХБАҮХАТухай хуулийг мөрдөн ажиллахыг Тамгын газрын нягтлан бодогч болон хөрөнгө оруулалт, худалдан авалт хариусан нягтлан бодогч нарт зөвлөсний дагуу 2017 оны төсөвт батлагдсан худалдан авалтыг байгууллагын вэб сайтад нээлттэй зарлан мэдээлсэн байна.

- Мөн тайлант хугацаанд урсгал засварын зардлын ангиллаас нийт 111.8 сая төгрөгийн зарцуулалт хийгдснээс Билэгт багана ХХК-иар байгууллагын 1 давхарын шал, 101 тоот өрөөний засвар, конторын сантехник болон спорт заалны дээвэр, дотоод заслын ажлыг тус тус гэрээгээр гүйцэтгүүлж нийт 65.6 сая төгрөгийг төлж, зардалд бүртгэсэн байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад УЕП-ын Тамгын газарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. 2016 онд санхүүгийн тайланд тайлагнагдсан мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4.1 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн кассын үлдэгдэл бөгөөд няравтай тооцоо нийлж, бэлэн мөнгөний тооллогын баталгаа үйлдээгүй байна.

Завсрын аудитаар 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр касс, жижиг мөнгөн сангийн хөрөнгийн үлдэгдэлд гэнэтийн тооллого хийхэд жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 109,784 төгрөгөөр илүүдэлтэй гарсан.

Иймд аудитын давтан шалгах горимын дагуу 2017 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр тус байгууллагын касс, жижиг мөнгөн сангийн үлдэгдэлд гэнэтийн тооллого хийхэд жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 915,000 төгрөг бөгөөд бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн орлого, зарлагын баримтаар тулгалт хийж, хөөн шалгахад нийт 2.5 сая төгрөгийн орлого авч, 1.0 сая төгрөгийн зарлага гаргаж, 39,500 төгрөгийг Мөнхбаатарт бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдлөөр, 545,500 төгрөгийг ерөнхий нягтлан бодогчид нотлох баримтгүйгээр өгсөн байв.

Мөн тайлант хугацаанд ЖМС-гийн дансаар нийт 35.3 сая төгрөгийн орлого бүртгэж, нийт 35.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гаргасны 46.2 хувь буюу 16.3 сая төгрөг нь 200,000 төгрөгөөс дээш үнийн дүнтэй 24 ажил гүйлгээний зарцуулалт байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, мөн хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох” 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна” гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

2. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн кассын үлдэгдэл 4.1 сая төгрөгөөр тайлагнагдсан бол тооллогоор 111,000 төгрөгийн үлдэгдэлтэй гарч, нийт 4.0 сая төгрөг дутагдсан. Гэвч нярав тайлбарлахдаа 2017 оны удирдах ажилтаны зөвөлгөөнд зарцуулсан гэх боловч тооллогын үед түүнийг нотлох баримт байгаагүй болно.

Тайлант онд уг дансанд цайны газрын түрээсийн орлого 8.3 сая, сургалтын танхимын түрээсийн орлого 2.7 сая, туслах үйл ажиллагаа буюу малын орлого 1.2 сая, нярав Ц.Батболдоос 0.6 сая, нийт 12.8 сая төгрөгийн орлогыг бүртгэж, нийт 8.7 сая төгрөгийн зарцуулалтыг гаргаж 4.1 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Иймд нэмэлт санхүүжилтийн кассад бүртгэж, тайлагнасан орлого зарлагын гүйлгээг хөөн шалгахад дараах асуудлууд илэрсэн болно.

- Тайлант онд цайны газруудтай байгуулсан түрээсийн гэрээний дагуу түрээсийн орлогыг давтан тооцоолоход 1.8 сая төгрөгийн түрээсийн орлогыг төв байрны цайны газрын түрээслэгч Ц.Болорцэцэгээс аваагүй байсан

- бөгөөд гэрээний заалтын дагуу жилийн эцэст нийт төлбөл зохих түрээсийн орлого, алдангийн хамт 2.0 сая төгрөг болсон байна.
- Уг дансанд сургалтын төвийн танхимын түрээсийн орлого гэж 2.6 сая төгрөгийн орлого орсон боловч төсөв зарцуулах эрх бүхий бус албан тушаалтны цохолтоор нийт 2.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хийж, баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.
 - Уг данснаас нийт 0.9 сая төгрөгөөр байгууллагын мэндчилгээ, дугтуй хийлгэсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох” 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

-Сангийн сайдын баталсан мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллаж, хүчин төгөлдөр анхан шатны нотлох баримтаар ажил гүйлгээг бүртгэж, баримтын бүрдүүлэлтийг хангаж, няравын ажил үүргийг зөв чиглүүлж, арга зүйгээр хангаж, ажлын хариуцлагыг дээшлүүлж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

-Түрээсийн орлогыг бэлнээр авч зарцуулалт гаргасан үйл ажиллагааг таслан зогсоож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай түрээсийн гэрээ байгуулах, төсвийн төслөөр төсөвт байгууллагын өөрийн орлогыг бодитой төлөвлөж, Сангийн яамны зөвшөөрөлтэйгөөр нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж байх;

3. УЕП-ын Тамгын газраас авсан судалгаагаар тус байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тайлагнагдсан авлагын үлдэгдэл 8.4 сая, өглөгийн үлдэгдэл 212.8 сая төгрөг ба өмнөх оны мөн үеэс авлага 2 дахин буюу 4.4 сая төгрөгөөр, өглөг 16.3 хувь буюу 29.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Нийт авлагын үлдэгдлийн 91.7 хувь буюу 7.7 сая, өглөгийн үлдэгдлийн 99.9 хувь буюу 212.8 сая төгрөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулсан байна. Тайлант онд авлага, өглөгийн дансны үлдэгдэл өмнөх оны мөн үеэс өссөнд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна.

Тухайлбал:

- 2016 оны жилийн эцэст Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэстэй тооцоо нийлсэн баримт цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлангаар нийт 7.7 сая төгрөгийн татварын илүү төлөлттэй гарсан байна.
- 2016 оны төсвийн тодотголоор УЕП-ын томилолтын болон сургалтын зардал хасагдаж батлагдсан боловч 2016 оны 9-12 дугаар сарын хоорондох хугацаанд УЕП-ын Б/243, Б/327, Б/333 дугаар тушаалаар гадаад томилолт болон УБ хотод прокуроруудын сургалтын хөтөлбөр боловсруулах Тайваны Хууль зүйн академтай хамтарсан сургалт зохион байгуулах зэрэг зардалд

нийт 25.7 сая төгрөгийг зарцуулахаар тооцоолсноос 19.5 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

- 2016 оны 8 дугаар сарын 22-ны өдөр “Билэгт багана” ХХК-тай УЕП-ын газрын дотор сантехник, архивын заалны дээвэр болон дотор заслын ажлыг гүйцэтгүүлэхээр нийт 130.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч гэрээ байгуулсан хугацаа зөрүүтэй, захиалагч болон гүйцэтгэгчийг төлөөлж гэрээ байгуулсан холбогдох этгээдийн гарын үсэг зурагдаагүй, УЕП-ын Тамгын газрын орлогч даргын нэр буруу гэх мэт хүчин төгөлдөр бус баримтаар гэрээ байгуулж, 2016 оны 12 сарын 21-д урьдчилгаа төлбөрт 54.6 сая төгрөг төлж, жилийн эцэст 75.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Энэ нь УИХ-ын 2016 оны “МУ-ын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 47 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д үндэслэн төсвийн сахилга батыг сахиж, урсгал зардлыг бууруулж, шинээр нэмж өр төлбөр үүсгэхгүй байх;

4. Аудитын явцад тухайн байгууллагад бүртгэлтэй автомашинуудын шатахууны зарцуулалтын тооцооллыг давтан шалгахад дараах зөрчлүүд илэрсэн болно. Тухайлбал:

- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоол, Дэд бүтцийн сайдын 2004 оны “жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалын дагуу шалгахад Улсын ерөнхий прокурор нь хөдөө ажлын Ланд крузейр-200 /08-25 УБҮ/ автомашинаар хот дотор нийт 12,832 км явж, нийт 4.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан;
- Лексус-570 /10-50 УНЛ/ болон Ланд крузейр-200 /00-15 УБЗ/ автомашинуудаар зөвхөн УЕП-ын хоёр орлогч хөдөө ажлаар нийт 3,671 км явж, нийт 1.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан;
- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-д “төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см³-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэхийг хориглоно” гэснийг зөрчин тус байгууллагад 3498-5700см³ хөдөлгүүрийн багтаамжтай нийт 7 автомашин ашиглагдаж байна;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тус байгууллагын ажил үйлчилгээнд ашиглагдах автомашины дээд хязгаарыг баталж өгөөгүй байна;
- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайланд шатахууны зардлыг 61.9 сая төгрөгөөр тайлагнасан боловч шатахууны зарцуулалтын тайлангаар 58.8 сая төгрөг гарч, нийт 3.1 сая төгрөгийн шатахууны зардал илүү тусгагдсан байна.

5. Тус байгууллага туслах аж ахуйн малын данс бүртгэлд тайлант онд 1.0 сая төгрөгийн 47 толгой малын зарлага гарган, нийт 6.5 сая төгрөгийн дансны үнэ бүхий 424 толгой малыг бүртгэж, санхүүгийн тайланд тайлагнасан боловч малын орлого, нас дэвшилт, малын тооллого, тайлан тооцоог зохих

журмын дагуу хийгээгүй, мөн малыг зах зээлийн үнээр үнэлж бүртгэлд тусгаагүй байна.

Эдгээр нь УСНББОУС-1 Ерөнхий зүйлүүд 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах естой-үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг", батламж мэдэгдлийн Хэмжилт-д: "ААНБ ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн ба орлого зардлыг зөв хуваарилсан байх", Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" 388 дугаар тушаал, ЗГ-ын 2015 оны "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим аргам хэмжээний тухай" 184 дүгээр тогтоол, Дэд бүтцийн сайдын 2004 оны "жишиг норм батлах тухай" 19 дүгээр тушаалтай тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

-ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоол, Дэд бүтцийн сайдын 2004 оны "жишиг норм батлах тухай" 19 дүгээр тушаалыг тус бүр мөрдөж ажиллах, шатахууны нормыг баримтлах, УЕП-ын хөдөө унах зориулалт бүхий автомашиныг хот дотор унахыг таслан зогсоож, шатахууны зарцуулалт гаргахгүй байх;

-Туслах аж ахуйн малыг зах зээлийн үнээр бүртгэж, дахин үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгах, мөн малын орлого, нас дэвшилт, тооллого, тооцоог жилийн эцсийн санхүүгийн тайлангаас өмнө зохих журмын дагуу хийж, гүйцэтгэж байх;

6. Тайлант хугацаанд харилцах болон кассаас сургалт семинарын зардалд нийт 61.5 сая төгрөгийг зарцуулсны 38.8 сая төгрөг нь зөвхөн цай, кофе, хоолны зардал байна.

Тайлант хугацаанд урсгал засварын зардлын ангиллаас нийт 111.8 сая төгрөгийн зарцуулалт хийгдснээс автомашины сэлбэг хэрэгсэл, засварын зардалд 36.1 сая, Билэгт багана ХХК-иар байгууллагын 1 давхарын шал, 101 тоот өрөөний засварт, конторын сантехник болон спорт заалны дээвэр, дотоод заслын ажлыг тус тус гэрээгээр гүйцэтгүүлж нийт 65.6 сая төгрөгийг төлж, зардалд бүртгэсэн байна.

Аудитаар жижиг мөнгөн сан болон харилцах дансдын тайлант хугацаанд хийгдсэн ажил гүйлгээнээс /харилцах дансны нийт 2,955.2 сая төгрөгийн ажил гүйлгээний цалин НДШ-ээс бусад зардлын 61.4 хувь буюу 390.0 сая төгрөг/, жижиг мөнгөн сангийн нийт зарлагын 93.6 хувь буюу 33.1 сая төгрөгийн ажил гүйлгээг тус бүр түүвэрлэн шалгахад дараах байдалтай байна.

- Харилцах данснаас холбогдох хууль тогтоомж, журамтай нийцээгүй, ажил гүйцэтгэх гэрээнд заасан ажлаас өөр ажил гүйцэтгэсэн, нотлох баримт зөрүүтэй, гэрээ байгуулсан этгээдийн гарын үсэггүй баримтын бүрдэлт хангалтгүй нийт 13.1 сая, Тамгын газрын дотоод сургалтын цай хоолны зардалд 1.6 сая, цайны газарт авсан халуун тогоо, хөлдөөгч 1.1 сая, хошин

шогын үзүүлбэрийн талбарт 0.4 сая, нийт 3.1 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан;

- Мөн УЕП-ын 2016 оны А/53 дугаар тушаалаар “Прокурор-2016” мэргэжлийн II шатны тэмцээнд оролцогчидын шагналд нийт 3.4 сая төгрөгийг цалингийн сангаас олгосон;
- УЕП-ын 2016 оны Б/326 болон Б/363 дугаар тушаалаар хуулийн байгууллагуудын дунд зохион байгуулагддаг спортын тэмцээнд амжилт гаргасан оролцогчид болон ажилдаа идэвхи зүтгэл гарган үр бүтээлтэй ажилласан ажилтнуудад нийт 4.6 сая төгрөгийн шагнал олгож, байгууллагын цалингийн сангаас зарцуулсан;
- Жижиг мөнгөн сангаас баримтын бүрдэл дутуу, илүү дутуу баримт бүрдүүлсэн 3.2 сая, бараа материалын орлогод бүртгээгүй 0.2 сая, Тамгын газрын дотоод сургалтын цай хоолны зардалд 3.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ.

Эдгээр нь УСНББОУС-1, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон хойшлогдсон эсвэл зарцуулагдаагүй нэг удаагийн арга хэмжээний зардлыг бусад зардлын зүйлд шилжүүлэн зарцуулахгүй байх” мөн Сангийн сайдын 2014 оны 5 тоот тушаалын 6-р хавсралтын төсөвт зардлыг бүлгээр болон эдийн засгийн ангилалаар хянах тайлбартай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

-Сургалтанд оролцогчид нь томилолтын мөнгө аваад сургалтанд хамрагдаж буй тохиолдолд өдрийн 3-аар цай, хоолны зардал гаргаж, сургалт сименарын зардалд бүртгэж, төсөвт зардлыг нэмэгдүүлж байгааг таслан зогсоох;

-Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг мөрдөж, тухайн жилийн төсвийн төслөө бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийх, зайлшгүй хэрэгцээтэй бус мөнгөн зарлагыг гаргахгүй байж, урсгал санхүүжилтийг хэмнэж ажиллах;

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

УЕП-ын Тамгын газрын тайлант оны нийт батлагдсан төсөвт зардлын 79.6 хувь буюу 2,319.8 сая төгрөг нь цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл байна. Иймд дараагийн аудитаар цалингийн бодолт болон холбогдох эрх зүйн актыг судлан шалгавал зохилтой байна.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

УЕП-ын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 52.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 4 зөвлөмж өгч, аудитын хугацаанд 4.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн болно.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

УЕП-ын Тамгын газрын 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж 2 зөвлөмж өгснийг 80 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж болон албан шаардлагын хэрэгжилтийг 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 2/2651 дүгээр албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

УЕП-ын Тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан /8/-ыг хавсаргав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
2017 оны 2 дугаар сар



УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахимхаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740
Цахимхаяг:
chantsaldulamp@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар

Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IY байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Цахим хуудас: www.audit.mn

Менежментийн захидал

